



Konsorcium nevládních
organizací pracujících
s migranty v ČR | Consortium of Migrants
Assisting Organizations
in the Czech Republic

Гадаад иргэн оршин суух тухай хуулийн өөрчлөлт

1. Оршин суух зорилгоо бизнес эрхлэлтийн виз рүү шилжүүлэх

Хэрвээ та Чех улсад удаан хугацааны оршин суух зөвшөөрөлтэй, бас 5-аас доош жил амьдарч байгаа бөгөөд ирээдүйд визийн төрлөө бизнес эрхлэлт визээр солих хүсэлтэй бол хүсэлтээ хурдан өгөөрэй. Учир нь шинэчлэгдсэн хуулиар ажлын визээ бизнес эрхлэлт визээр солино гэвэл Чех улсад заавал 5-аас дээш жил болсон байх ёстой.

2. Оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгох үйл явц

Хэрвээ Дотоод хэргийн яам таны оршин суух зөвшөөрлийн үйл ажиллагааг хүчингүй болгосон бол та хурдан шуурхай хуулийн зөвлөгөө, тусламж аваарай. Таны оршин суух зөвшөөрлийг цуцлагдсан шийдвэртэй захиа ирсэн л бол мөн адил яаралтай хуулийн тусламж авч даван заалдах гомдлоо цаг тухайд нь өгнө үү.

3. Ажил олгогч солих

Хэрвээ та Чех улсад ажилтны картаар ажилладаг бөгөөд ирээдүйд Дотоод хэргийн яаманд өөрийн ажил олгогчоо солих хүсэлтээ өгөх гэж байгаа бол хүсэлтээ хурдан өгөөрэй. Гадаад иргэн оршин суух хуулийн шинэчилсэн өөрчлөлт орсны дараа дээрх өөрчлөлтийн хүсэлт өгөх процесс их хүндрэлтэй болж эхэлнэ. Жишээ нь хуучин ажил олгогчоос тусгай тодорхойлолт хэрэгтэй болно.

4. Хуулийн дагуу оршин суух хийсвэр зөвшөөрөлтэй байхад байнга оршин суух зөвшөөрлийн хүсэлт гаргах

Хэрвээ таны оршин суух визийн зөвшөөрөл гадаад паспортын хуудсан дээр наагдсан буюу өөр хэлбэл Фикце оршин суух зөвшөөрөлтэй ирээдүйд Байнга оршин суух зөвшөөрлөө авах хүсэлтэй байгаа бол хурдан хүсэлтээ өгөөрэй. Гадаад иргэн оршин суух хуулийн шинэчилсэн өөрчлөлт орсны дараа таны удаан хугацааны суух оршин суух зөвшөөрлийн хариуг Дотоод хэргийн яам хүлээх болно. Таны удаан хугацааны виз хүчинтэй (сунгагдсан) тохиолдолд танд Байнга оршин суун зөвшөөрөл олгоно.

5. Оршин суух зөвшөөрөлгүй гэр бүлийн гишүүд

Хэрвээ та Чех улсын иргэний гэр бүлийн гишүүн, бичиг баримтгүй, гарах захирамжаа авчихсан байгаа бол яаралтай удаан хугацааны оршин суух хүсэлтээ өгнө үү. Гадаад иргэн оршин суух хуулийн шинэчилсэн өөрчлөлт орсны дараа та заавал Чех улсаас гарч ЭСЯ-аас богино хугацааны виз хүсэх хэрэгтэй болно. Хэрвээ танд ийм тохиолдол байгаа бол заавал хуульчтай зөвлөнө үү. Учир энэхүү асуудлыг шүүхийн хүрээнд шийдэх хэрэгтэй байдаг.

6. Өөрийгөө тэжээн тэтгэх чадваргүй насанд хүрсэн хүүхдийн байнга оршин суух зөвшөөрөл



Konsorcium nevládních
organizací pracujících
s migranty v ČR | Consortium of Migrants
Assisting Organizations
in the Czech Republic

Хэрвээ та Чех улсад байнгын оршин суух зөвшөөрөлтэй таны хүүхэд 26 наснаас доош оюутан бөгөөд гэр бүл нийлүүлэх хүрээнд Та хүүхдийнхээ байнга оршин суух зөвшөөрлийн хүсэлтийг маш хурдан өгнө үү. Гадаад иргэн оршин суух хуулийн шинэчилсэн өөрчлөлт орсны дараа гэр бүл хамтран байнга оршин суух зөвшөөрөл хүсэх боломжгүй. Энэхүү төрлийг зөвшөөрлийг зөвхөн насанд хүрээгүй буюу 18 наснаас доош хүүхдэд хүсэх боломжтой.

7. Хүлээлгийн визээс оршин суух зөвшөөрлийн хүсэлт

Хэрвээ та Чех улсад хүлээлгийн зорилготой удаан хугацааны визтэй бөгөөд ажлын карт буюу гэр бүлтийн виз хүсэх зорилготой визийн хүсэлтээ аль болох даруйхан өгнө үү. Гадаад иргэн оршин суух хуулийн шинэчилсэн өөрчлөлт орсны дараа хүлээлгийн визтэй 3 жил болсны дараа ажилтны картны хүсэлт гаргах боломжтой. Гэр бүлтэй хамт суух зорилготой оршин суух хүсэлт гарахад зөвхөн хүлээлгийн визтэй 6-аас дээш сар болсны дараа боломжтой.

8. Нэгдэл буюу компанид ажилладаг хамт ажиллагч, захирал эсвэл нэгдэлийн гишүүдийн ажилтны карт

Хэрвээ ямар нэгэн компанийн захирал эсвэл хамтрагч болон тухай компанийн гишүүний зөвшөөрлөөр хэрвээ та байдаг бол, мөн дээрээс нь та ажилтны карттай, хөдөлмөр эрхлэх зөвшөөрөлтэй бол яаралтай хурдан визийнхээ зорилго өөрчлөх хэрэгтэй. Тухайлбал хэрвээ визээ бизнес эрхлэлтээр эсвэл ажил олгогчоо солих хэрэгтэй. Учир нь Гадаад иргэн оршин суух хуульд хуулийн шинэчилсэн өөрчлөлт орсны дараа та ямар нэгэн компанид харьяалалтай бөгөөд давхар ажилтны картаар хөдөлмөөр эрхлэх боломжгүй юм. Дотоод хэргийн яам энэ төрлийн ажилтны картыг дахин сунгахгүй. Мөн шинэ хууль батлагдсаны дараа хэрвээ та визээ бизнес эрхлэлтээр солин боломжгүй болно (хэрвээ Чех улсад 5-аас доош жил амьдарч байгаа бол).